



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТРЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/202/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: П.Амарсанаа
Утас: 261740 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Ниямазон аудит" ХХК
Захирал: З.Цээнээ
Цахим хаяг: audit@nmz.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Аудитын тайлан	15
3.1 Ерөнхий зүйл	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
БЗД	Баянзүрх дүүрэг
ЗГ	Засгийн газар
НА	Нотлох ажил
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮТББ	Нийтэд үйлчлэх төрийн бус байгууллага
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УДБЭТ	Улсын дуурь бүжгийн эрдмийн театр
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН
ТЕАТРЫН ЗАХИРАЛ Ц.ТӨВШИНТӨГС
ТАНАА

2022.02.24 № 07/352
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,211,823,330.85	1,319,012,541.76
33	АВЛАГА	24,196,269.10	25,712,769.10
33300	Татаас, санхүүжилтийн авлага	24,196,269.10	0.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	0.00	1,712,769.10
335	Бусад авлага	0.00	24,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	24,000,000.00
34	УРЬДЧИЛГАА	6,650,000.00	0.00
34600	Урьдчилж гарсан зардал	6,650,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,180,977,061.75	1,293,299,772.66
351	Түүхий эд материал	58,104,971.18	121,591,330.74
35110	Тусгай зориулалттай материал	4,999,333.40	4,109,490.74
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	53,105,637.78	117,481,840.00
354	Хангамжийн материал	1,122,872,090.57	1,171,708,441.92
35410	Бичиг хэргийн материал	1,189,600.00	154,100.00
35420	Аж ахуйн материал	64,545,880.73	42,081,232.90
35440	Түлш, шатах тослох материал	357,138.90	188,539.00
35470	Бусад хангамжийн материал	986,325,923.52	1,066,382,125.30
35420	Нормын хувцас	70,453,547.42	62,902,444.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,408,873,999.47	3,080,176,120.05
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,408,873,999.47	3,080,176,120.05
392	Биет хөрөнгө	3,198,508,354.47	2,869,810,475.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,128,338,957.19	3,128,338,957.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(420,652,456.74)	(630,004,044.18)
39203	Авто тээврийн хэрэгсэл	116,920,000.00	116,920,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(89,720,000.06)	(92,920,000.10)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,271,663,013.43	1,297,567,413.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	(941,354,461.22)	(1,061,708,696.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	234,322,780.66	236,700,280.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(201,196,977.63)	(209,444,043.60)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	12,715,000.00	12,715,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	351,149,730.00	351,149,730.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(263,677,231.16)	(279,504,121.38)
393	Биет бус хөрөнгө	210,365,645.00	210,365,645.00
39301	Програм хангамж	5,725,000.00	5,725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,725,000.00)	(5,725,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	210,365,645.00	210,365,645.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,620,697,330.32	4,399,188,661.81
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,620,697,330.32	4,399,188,661.81
51	Засгийн газрын хувь оролцоо	1,684,145,237.49	1,684,145,237.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	1,684,145,237.49	1,684,145,237.49
51101	Өмч: - төрийн	1,684,145,237.49	1,684,145,237.49
512	Хуримтлагдсан үр дүн	(929,816,642.45)	(1,151,325,310.96)

51210	Өмнөх үеийн үр дүн	(769,728,718.80)	(929,816,642.45)
51220	Тайлант үеийн үр дүн	(160,087,923.65)	(221,508,668.51)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,866,368,735.28	3,866,368,735.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,620,697,330.32	4,399,188,661.81

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,706,189,020.00	4,555,885,203.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1,654,400.00
122	Тусламжийн орлого	0.00	1,654,400.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	1,654,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,706,189,020.00	4,554,230,803.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,536,382,100.00	4,408,576,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,536,382,100.00	4,408,576,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	169,806,920.00	145,654,503.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	50,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	169,806,920.00	95,654,503.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,866,276,943.65	4,777,393,871.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,423,388,939.84	4,777,393,871.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,423,388,939.84	4,378,031,468.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,337,255,656.12	3,299,462,790.30
210101	Үндсэн цалин	2,017,486,896.78	2,348,521,636.03
210102	Нэмэгдэл	1,097,902,039.34	604,757,154.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	221,866,720.00	346,184,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	421,589,419.09	430,132,115.91
210201	Тэтгэврийн даатгал	279,521,719.09	301,985,155.63
210202	Тэтгэмжийн даатгал	35,516,900.00	33,728,433.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,413,500.00	26,505,627.18
210204	Ажилгүйдлийн даатгал	7,103,400.00	6,109,358.21
210205	Эрүүл мэндийн даатгал	71,033,900.00	61,803,541.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,361,261.26	65,764,875.22
210301	Гэрэл, цахилгаан	40,279,530.00	14,769,758.42
210302	Түлш, халаалт	39,998,180.37	45,920,978.80
210303	Цэвэр, бохир ус	4,083,550.89	5,074,138.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,679,100.08	26,331,598.07
210401	Бичиг хэрэг	3,141,565.00	3,751,250.00
210402	Тээвэр, шатахуун	3,759,861.10	2,052,199.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,020,684.48	2,961,086.24
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,871,500.00	6,246,803.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,665,635.00	8,826,182.93
210408	Бараа материал акталсны зардал	24,219,854.50	2,494,076.00

2105	Нормативт зардал	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,673,886.00	43,874,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,684,016.00	381,800.00
210604	Урсгал засвар	9,989,870.00	43,492,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	161,376,658.95	154,909,509.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	155,631,388.95	147,095,399.76
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,945,150.00	2,893,360.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	122,420.00	227,720.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	56,570.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	1,392,000.00
210807	Газрын төлбөр	677,700.00	1,244,460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	352,452,958.34	357,556,479.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,442,259.03	576,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	351,010,699.31	356,979,779.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	442,888,003.81	399,362,402.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	197,345,400.00	74,969,626.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	195,345,400.00	67,769,626.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	7,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	245,542,603.81	324,392,776.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	245,542,603.81	323,892,776.83
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(160,087,923.65)	(221,508,668.51)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(160,087,923.65)	(221,508,668.51)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,706,188,970.00	4,576,868,303.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,706,188,970.00	4,576,868,303.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,536,382,100.00	4,408,576,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,536,382,100.00	4,408,576,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	169,806,870.00	168,292,003.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	50,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	169,806,870.00	118,292,003.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,706,188,970.00	4,551,440,803.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,706,188,970.00	4,551,440,803.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,240,663,516.19	4,152,078,400.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,337,200,694.29	3,299,462,790.30
210101	Үндсэн цалин	2,017,431,934.95	2,115,859,294.16
210102	Нэмэгдэл	1,097,902,039.34	837,510,205.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	221,866,720.00	346,093,290.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	421,368,418.34	430,132,115.91
210201	Тэтгэврийн даатгал	279,300,718.34	302,033,534.15
210202	Тэтгэмжийн даатгал	35,516,900.00	33,706,832.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,413,500.00	26,498,427.74
210204	Ажилгүйдлийн даатгал	7,103,400.00	6,107,782.34
210205	Эрүүл мэндийн даатгал	71,033,900.00	61,785,539.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,361,261.26	65,764,875.22
210301	Гэрэл, цахилгаан	40,279,530.00	14,769,758.42
210302	Түлш, халаалт	39,998,180.37	45,920,978.80
210303	Цэвэр, бохир ус	4,083,550.89	5,074,138.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,820,344.48	20,357,008.74
210401	Бичиг хэрэг	3,252,000.00	2,539,100.00
210402	Тээвэр, шатахуун	3,217,000.00	1,883,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,020,684.48	3,171,086.24
210404	Ном, хэвлэл	483,180.00	281,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,871,500.00	8,385,393.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,975,980.00	4,096,829.50
2105	Нормативт зардал	16,100,000.00	17,660,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,100,000.00	17,660,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,209,470.00	45,256,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	42,068,600.00	2,374,750.00
210602	Тавилга	4,350,000.00	0.00
210604	Урсгал засвар	10,790,870.00	42,881,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	280,523,727.82	271,351,990.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	274,397,257.82	263,537,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,945,150.00	2,893,360.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,720.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,700.00	56,570.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	381,200.00	1,392,000.00
210807	Газрын төлбөр	677,700.00	1,244,460.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,079,600.00	2,093,570.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,079,600.00	2,093,570.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	465,525,453.81	399,362,402.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	197,345,400.00	74,969,626.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	195,345,400.00	67,769,626.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	7,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	268,180,053.81	324,392,776.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	268,180,053.81	323,892,776.83
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	25,427,500.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	25,427,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	25,427,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	25,427,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	25,427,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	(25,427,500.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,368,735.28	(769,728,718.80)	4,780,785,253.97
Тайлант үеийн үр дүн			(160,087,923.65)	(160,087,923.65)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,368,735.28	(929,816,642.45)	4,620,697,330.32
Тайлант үеийн үр дүн			(221,508,668.51)	(221,508,668.51)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,684,145,237.49	3,866,368,735.28	(1,151,325,310.96)	4,399,188,661.81

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,431,750,600.00	4,084,683,523.17	347,067,076.83	92.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,431,750,600.00	4,084,683,523.17	347,067,076.83	92.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,329,004,800.00	4,012,935,897.17	316,068,902.83	92.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,551,693,500.00	3,299,462,790.30	252,230,709.70	92.9
210101	Үндсэн цалин	2,451,746,500.00	2,115,859,294.16	335,887,205.84	86.3
210102	Нэмэгдэл	884,487,000.00	837,510,205.41	46,976,794.59	94.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	215,460,000.00	346,093,290.73	(130,633,290.73)	160.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	479,478,600.00	430,132,115.91	49,346,484.09	89.7
210201	Тэтгэврийн даатгал	337,410,900.00	302,033,534.15	35,377,365.85	89.5
210202	Тэтгэмжийн даатгал	35,516,900.00	33,706,832.52	1,810,067.48	94.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,413,500.00	26,498,427.74	1,915,072.26	93.3
210204	Ажилгүйдлийн даатгал	7,103,400.00	6,107,782.34	995,617.66	86.0
210205	Эрүүл мэндийн даатгал	71,033,900.00	61,785,539.16	9,248,360.84	87.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,019,300.00	65,764,875.22	13,254,424.78	83.2
210301	Гэрэл, цахилгаан	32,913,700.00	14,769,758.42	18,143,941.58	44.9
210302	Түлш, халаалт	38,672,200.00	45,920,978.80	(7,248,778.80)	118.7
210303	Цэвэр, бохир ус	7,433,400.00	5,074,138.00	2,359,262.00	68.3
2104	Хангамж, бараа материалын зардал	18,250,800.00	17,713,605.74	537,194.26	97.1
210401	Бичиг хэрэг	2,414,200.00	2,539,100.00	(124,900.00)	105.2
210402	Тээвэр, шатахуун	1,883,600.00	1,883,600.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,330,800.00	3,171,086.24	1,159,713.76	73.2
210404	Ном, хэвлэл	410,700.00	281,000.00	129,700.00	68.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,586,900.00	5,741,990.00	(155,090.00)	102.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,624,600.00	4,096,829.50	(472,229.50)	113.0
2105	Нормативт зардал	17,660,000.00	17,660,000.00	0.00	100.0

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,660,000.00	17,660,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,243,400.00	3,159,550.00	83,850.00	97.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,458,600.00	2,374,750.00	83,850.00	96.6
210604	Урсгал засвар	784,800.00	784,800.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	179,380,400.00	178,780,390.00	600,010.00	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,966,300.00	170,966,300.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,000,000.00	500,000.00	80.0
210803	Даатгалын үйлчилгээ	2,961,000.00	2,893,360.00	67,640.00	97.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	56,570.00	31,430.00	64.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,392,000.00	1,392,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	1,245,400.00	1,244,460.00	940.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	278,800.00	262,570.00	16,230.00	94.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	278,800.00	262,570.00	16,230.00	94.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,745,800.00	71,747,626.00	30,998,174.00	69.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,745,800.00	71,747,626.00	30,998,174.00	69.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	98,767,800.00	67,769,626.00	30,998,174.00	68.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,978,000.00	3,978,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,431,750,000.00	4,084,683,523.17	347,066,476.83	92.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,431,750,000.00	4,084,683,523.17	347,066,476.83	92.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,431,750,000.00	4,084,683,523.17	347,066,476.83	92.2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	285	285	0	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	226	226	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	57	57	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		168,292,003.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		168,292,003.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		164,570,003.00
2104	Хангамж, бараа материалын зардал		2,643,403.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		2,643,403.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		67,524,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		23,050,000.00
210602	Тавилга		2,377,500.00
210604	Урсгал засвар		42,096,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		92,571,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		92,571,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,831,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,831,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		3,222,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,222,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		500,000.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		168,292,003.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		0.00
1311	НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		168,292,003.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		50,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		118,292,003.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад түүх соёлын дурсгалт зүйлсийн хөрөнгийн бүртгэлийг сайжруулах, газрын эзэмшлийг баримтжуулах, хувь хүний татварын авлагыг барагдуулах, татвар шимтгэлийн өр авлага үүсгэхгүй ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 18-ны хооронд “Ниямазон аудит” ХХК-ийн аудитор Т.Оюун гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Батнасан, захирал З.Цээнээ нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын зорилго нь үндэсний болон сонгодог урлагийн бүтээлээр иргэдэд үйлчлэх, соёлын арга хэмжээ, тоглолт үйлчилгээг олон түмэнд хүргэж сурталчлах юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Соёлын тухай хууль;
- ЗГ-ын 2021оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр дотоод аудитын нэгжгүй, дотоод аудитын тусгайлсан ажилтангүй. Дотоод хяналтыг захиргааны болон алба, ангийн дарга нарын ажлын байрны тодорхойлолтонд тусгаж хэрэгжүүлдэг.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 4,706,189.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 47,061.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 221,508.6 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	24,196.3	25,712.8	1,516.5
Урьдчилгаа	6,650.0	-	(6,650.0)
Бараа материал	1,180,977.0	1,293,299.8	112,322.8
Үндсэн хөрөнгө	3,408,874.0	3,080,176.1	(328,697.9)
Нийт хөрөнгө	4,620,697.3	4,399,188.7	(221,508.6)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо/ Эздийн өмч	4,620,697.3	4,399,188.7	(221,508.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/ өмчийн дүн	4,620,697.3	4,399,188.7	(221,508.6)

Авлага дансны үлдэгдэл 25,712.8 мянган төгрөг болж 1,516.5 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны татан төвлөрүүлсэн 22,637.5 мянган төгрөгийг буцаан авсан, Монголын хүүхдийн кино урлагийн шинэ дэлгэц төв НҮТББ-аас авах 24,000.0 мянган төгрөгийн авлага, нийгмийн даатгалын шимтгэлийн 154.0 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 6,650.0 мянган төгрөгөөр буурсан нь эрдэм шинжилгээний хурлын зардлыг хүлээн зөвшөөрснөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,293,299.8 мянган төгрөг болж 112,322.8 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын худалдан авалт, дуусаагүй үйлдвэрлэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант онд 2,494.0 мянган төгрөгийн бараа материалыг

акталжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,080,176.1 мянган төгрөг болж 328,697.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 7,250.0 мянган төгрөгийн компьютер, өөрийн хөрөнгөөр 17,000.0 мянган төгрөгийн 2 ариутгалын хаалга, 2,377.5 мянган төгрөгийн нүүр будгийн 5 ширээ худалдан авч, Соёлын яамнаас үнэ төлбөргүй 1,654.4 мянган төгрөгийн зөөврийн компьютер шилжүүлэн авч данс бүртгэлд тусгасан, 356,979.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,399,188.7 мянган төгрөг болж, 221,508.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 150,303.8 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Соёлын яамнаас 2021 оны 8 сард “Сонгодог урлаг OPEN AIR” хөтөлбөрт зориулж 150,000.0 мянган төгрөг төлөвлөж 135,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч 9 сард тус санхүүжилтийг буцааж төвлөрүүлсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт ба үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого байна. Ковид-19 цар тахалтай холбоотой хөл хорионы улмаас тоглолт бага хийгдсэн учир үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого 74,152.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 88,883.1 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс ба нэмэгдэл урамшил, хангамж бараа материалын зардал, урсгал засварын зардлууд байна. Энэ нь цалин хөлс, нэмэгдэл урамшил, хангамж бараа материалын зардлууд хэмнэгдэж, урсгал засварын зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,664,652.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,664,652.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 232,901.5 мянган төгрөгөөр бууруулж 4,431,750.6 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс төсвийн хэмнэлттэй уялдуулан эд хогшил худалдан авах зардлыг 93,957.9 мянган төгрөгөөр, дотоод томилолтын зардлыг 35,000.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 41,883.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 13,120.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 8,144.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг 40,796.5 мянган төгрөгөөр бууруулан баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,431,750.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 4,431,750.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,408,576.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 4,084,683.5 мянган төгрөгийг зарцуулж 323,892.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,084,683.5 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 301,577.2 мянган төгрөгөөр, байр ашиглалтын болон бусад зардлыг 22,315.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн хэмнэлт нь соёл урлагийн арга хэмжээний 1 хөтөлбөрийг 347,067.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71702	Соёл урлаг	4,431,750.6	4,084,683.5	347,067.0	92.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 50,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 118,292.0 мянга, нийт 168,292.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал засварт 42,096.5 мянга, тавилга худалдан авахад 2,377.5 мянга, тоног төхөөрөмж худалдан авахад 23,050.0 мянга, хог хаягдал, ариутгалын зардалд 2,643.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 92,571.6 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 3,222.0 мянга, бусад зардалд 1,831.0 мянга, нийт 167,792.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 500.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

УДБЭТеатр нь үндсэн 285 ажилтантай, захиргаа хүний нөөцийн алба, санхүүгийн алба, маркетингийн алба үйлчилгээний алба уран бүтээлийн удирдах алба гэсэн 5 албанаас бүрддэг. Уран бүтээлийн удирдах алба нь дотороо хөгжим анги, гоцлол дууны анги, бүжиг анги, найрал дууны анги, үйлдвэр тайз анги гэсэн 5 нэгжтэй.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 80.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр хүүхдэд зориулсан “Баавгай дуулах уу” хүүхдийн дуурийг Уран сайхны зөвлөлөөр баталгаажуулан хувцас хэрэглэл, тайз чимэглэлийг бэлтгэж хүүхдийн хүртээл болоход бэлэн болгожээ. Дээд шатны төсвийн захирагчаас олгосон санхүүжилтээр “Шивээ хиагт” дуурийг сэргээн туурвиж хөл хорионоос шалтгаалж 1 удаа тогложээ.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь

өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

3.8 Аудитын гол асуудал

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр өмнөх аудитын зөвлөмжөөр НБББББ-д Сангийн сайдын тушаалаар баталсан анхан шатны маягт, маягтыг хөтлөх зааврыг нэмэлт өөрчлөлт болгож оруулсан.

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

2021 онд нийт 5,968,700.0 мянган төгрөгийн 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 12,800.0 мянган төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.1 *“Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”* гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын хэрэгжилтийг шалгахад 323,892.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн, бусад зардлын хэмнэлтийг тооцоход 14,491.7 мянган төгрөгийн буюу 4.9 хувийн хэмнэлт гаргаж ажилласан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 *“үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 5,999.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг жилийн эцэст дахин хянаж үзэхэд бүрэн биелүүлсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна. Аудитаар өгсөн 738.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	-	-	1	-	-
Зөвлөмж	2	738.4	2	738.4	-	-	100.0
Нийт дүн	3	738.4	5	738.4	-	-	66.7

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрт ШШГЕГ-аас 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 22280015/153 тоот мэдэгдлээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд төлөх 17,830.6 мянган төгрөгийг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын дансанд төлөхийг мэдэгдсэн байна. Тус ажилтанд 2 удаа сахилгын шийтгэл ногдуулж 3 дахь удаагийн зөрчилд нь ажлаас чөлөөлөх шийдвэр гаргасан нь захиргааны зөвлөлийн шийдвэр, захирлын тушаалаар нотлогдож буй хэдий ч давж заалдах шатны шүүхийн шийдвэр, уг шийдвэрийн тухайд гаргасан театрын гомдлыг дээд шүүхийн иргэний хэргийн танхимаас хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзсан учир Улсын дуурь бүжгийн эрдмийн театраас 17,830.6 мянган төгрөгийг албадан гаргуулах магадлалтай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 158,858.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 136,712.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,364.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 22,145.6 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшиний 47,061.9 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Хувь хүний татварын холбогдолтой татварын албанд илүү төлсөн 1,558.8 мянган төгрөгийн авлагыг ажиллагсадтай холбогдсон авлагаар, нийгмийн даатгалын 154.0 мянган төгрөгийн авлагыг байгууллагаас авах авлагаар тайлагнасныг татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаар тайлагнаж нийт 1,712.8 мянган төгрөгийн авлагын ангиллыг залруулав.
- Дээд шатны төсөв захирагчаас олгосон 135,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг буцаан шилжүүлсэн гүйлгээг санхүүгийн тайлангийн орлого болон зарлагаас хасч залруулав.

4.2 Төлбөрийн акт

Тэтгэвэрт гарсан ажилтныг үндсэн ажилтнаар ажиллуулж нэмэгдэл цалинд 2,364.1 мянган төгрөг илүү олгосон нь Төрийн албаны зөвлөлийн Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр 01/662 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн 2 дугаар заалт, 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 07 тоот зөвлөмжийн 8 дугаар заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хэмжилтийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тэтгэвэрт гарсан ажилтанд илүү олгосон нэмэгдэл цалин 2,364.1 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Газрын гэрчилгээтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

БЗД-т байрлах театрын аж ахуйн зориулалттай 18,222.7 мянган төгрөгийн үнэлгээтэй 1375.3 м2 хэмжээтэй газар нь кадастрын зургаар баталгаажсан боловч газрын гэрчилгээгүй байна. Энэ нь Газрын тухай хуулийн 27.4 "Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно", оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Кадастрын зургийн дагуу газрын гэрчилгээг гаргуулж, эзэмшлийг баталгаажуулах.

2. Түүх соёлын дурсгалт зүйлстэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Түүх соёлын дурсгалт зүйлсийг дахин үнэлэх, сэргээн засварлах шаардлагатай, хөрөнгийн зурагтай дэлгэрэнгүй бүртгэл байхгүй, тайлбаргүй байгаа нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйл 21.2 "Соёлын өвийн бүртгэл нь дараах дагалдах хэрэглэгдэхүүнээс бүрдэнэ", 21.2.6 "гэрэл зураг, түүнийг агуулсан хальс, зээрэнцэг", үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Түүх соёлын дурсгалт зүйлсийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх, зурагжуулж баримтжуулах, үнэт эдлэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэх.

3. Хувь хүний орлогын албан татварын авлагатай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Татварын албанд илүү төлсөн 1,558.8 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын авлагыг барагдуулаагүй.

3.2. Өгсөн зөвлөмж:

Хувь хүний татварын авлагыг барагдуулах, төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	УДБЭТ	АХГ-2022/202/НА-СТА-ТШЗ	ХХОАТ-ын авлагыг ажиллагсадтай холбоотой, НДШ-ийн авлагыг байгууллагаас авах авлагаар бүртгэсэн	Авлагын ангиллыг залруулж тайлагнасан	1	1,712.8	1	1,712.8						
2	УДБЭТ	АХГ-2022/202/НА-СТА-ТШЗ	Дээд шатны төсөв захирагчаас олгосон санхүүжилтийг буцаасан гүйлгээг орлого, зарлагаар тусгасан	Орлого болон зардлаас хасаж залруулсан.	1	135,000.0	1	135,000.0						
3	УДБЭТ	АХГ-2022/202/НА-СТА-ТШЗ	Тэтгэврийн хүнийг үндсэн ажилтнаар ажиллуулж нэмэгдэл цалин олгосон	Нэмэгдэл цалинг төлүүлэх	1	2,364.1			1	2,364.1				
4	УДБЭТ	АХГ-2022/202/НА-СТА-ТШЗ	БЗД-т байрлах театрын аж ахуйн зориулалттай 1375.3 м2 хэмжээтэй газар кадастрын зургаар баталгаажсан боловч газрын гэрчилгээгүй.	Кадастрын зургийн дагуу газрын гэрчилгээг гаргуулж, эзэмшлийг баталгаажуулах.	1	18,222.7							1	18,222.7
5	УДБЭТ	АХГ-2022/202/НА-СТА-ТШЗ	Түүх соёлын дурсгалт зүйлсийн зурагтай дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх, сэргээн засварлах шаардлагатай	Түүх соёлын дурсгалт зүйлсийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх, зурагжуулж баримтжуулах, үнэт эдлэлд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэх.	1	-							1	-

Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

6	УДБЭТ	АХГ- 2022/202/НА- СТА-ТШЗ	Татварын албанд илүү төлсөн хувь хүний орлогын албан татварын авлагыг барагдуулаагүй	Хувь хүний татварын авлагыг барагдуулах, цаашид татвар, шимтгэлийн өр авлага үүсгэхгүй ажиллах.	1	1,558.8							1	1,558.8
	ДҮН				6	158,858.4	2	136,712.8	1	2,364.1			3	19,781.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	УДБЭТ	АХГ- 2022/202/НА- СТА-ТШЗ	Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон	Шилэн дансанд мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэх	1	12,800.0					1	12,800.0		
	ДҮН				1	12,800.0					1	12,800.0		-
НИИТ ДҮН					7	171,658.4	2	136,712.8	1	2,364.1	1	12,800.0	3	19,781.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 262/А0150458
АХГ-2022/202/СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн аудитын тайлангаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд 12,800,000.00 төгрөгийн ажил, гүйлгээний 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулан зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын захирал Ц.Төвшинтөгст даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
З.ЦЭЭНЭЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-262.Docx

0010800814



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 48/АД150458
АХГ-2022/002/СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын дуурь бүжгийн эрдмийн театр нь тайлант хугацаанд байгууллагаас тэтгэвэрт гарсан ажилтныг буцаан авч ажиллуулахдаа ур чадварын нэмэгдэл 711,980.00 төгрөг, амралтын олговор 1,652,101.00 төгрөг, нийт 2,364,081.00 төгрөгийг тус тус илүү олгосон байна.

Энэ нь Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01/662 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн 2 дугаар зүйл "...өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэн төрийн байгууллагад байнгын бус шинжтэй ажил үүргийг Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хуульд нийцүүлэн хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ зэргийг байгуулсны үндсэн дээр гүйцэтгэх боломжтой юм. Энэ нөхцөлд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнд төрийн албан тушаалд ажиллаж байсан үеийн цалин хөлсийг олгох, цол зэрэг дэвийг эдлүүлэх хууль зүйн үндэслэлгүй бөгөөд ажлын хөлсийг талууд харилцан тохиролцон тогтоох нь зүйтэй", 2020 оны 07 тоот зөвлөмжийн 8 дугаар зүйл "Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үндэслэлээр чөлөөлөгдсөн хүнийг төрийн албаны сонгогддогдоос бусад үндсэн албан тушаалд томилон ажиллуулж болохгүй. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг зөвхөн гэрээний үндсэн дээр, төрийн албан хаагчийн эрх зүйн байдалгүйгээр тодорхой хугацаанд ажил үүрэг гүйцэтгүүлж болно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилтанд олгосон ур чадварын нэмэгдэл болон амралтын олговор болох нийт 2,364,081.00 /хоёр сая гурван зуун жаран дөрвөн мянга наян нэгэн/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын захирал Ц.Төвшинтөгс, ерөнхий нягтлан бодогч Н.Анхтөр нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

З.ЦЭЭНЭЭ

[illegible]

[illegible]